

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:

“ХҮИИ.6. “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах ажлын явцын талаар Зам, тээврийн сайд М.Зоригт Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан уг хэлэлцээрийн төслийг Орос, Хятадын талтай яаралтай эцэслэн тохирч, дүнг Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн сайд М.Зоригтод даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР